



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/30

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.-ийн "г", Захиргааны ерөнхий хуулийн 40.2.4 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 2.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар хурлаар иргэдийн өргөдөл, хүсэлтийг хэлэлцэн эрүүл мэнд болон амьдралын аргагүй байдлыг нь харгалзан үзэж Мөрөн сумын иргэн Д.Амарбаясгаланд 300000 төгрөг, Я.Дашзэвэгт 1000000 төгрөг, М.Энхдалайд 1000000 төгрөг, А.Догсмаад 200000 төгрөг, Ө.Ундармаад 100000 төгрөг, Н.Тунгалагт 100000 төгрөг, Ж.Өлзийбуянд 50000 төгрөг, Баянзүрх сумын иргэн Н.Саранд 100000 төгрөг, Арбулаг сумын иргэн Г.Гантогтоход 72000 төгрөгний дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй

2. Дээрх 2922000 (Хоёр сая есөн зуун хорин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД